



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/103

Мандалговь

Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл  
ажлын байрыг шалгаруулах аймгийн дэд  
комиссын бүрэлдэхүүнийг  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай Засгийн газрын 24 дүгээр тогтоолын 2, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4 дүгээр зүйлийн 2.4.1 дэх заалтын 2.4.1.6 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/472 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулах аймгийн дэд комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Дарга: - Аймгийн Засаг даргын орлогч  
Гишүүд: - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга  
- Эрүүл мэндийн газрын дарга  
- Засаг даргын Тамгын газрын эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн  
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга  
- Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуй, хяналтын улсын байцаагч  
Нарийн бичгийн дарга: - Эрүүл мэндийн газрын мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

2. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулах аймгийн дэд комиссыг мэргэжлийн удирдлагаар ханган, Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байрыг шалгаруулах үйл ажиллагааг Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/472 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Анхбаярт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



481210381